



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03.

Улаанбаатар хот

Солонгос хэлтэй хөтөч тайлбарлагчдын
ур чадварыг дээшлүүлэх
сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Солонгос хэлтэй хөтөч тайлбарлагчдын ур чадварыг дээшлүүлэх сургалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 300,000 /гурван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетингийн стратеги боловсруулах, тэдэнд учирдаг хүндрэл бэрхшээлийг арилгах, нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засагт оруулж буй зэрэг нөлөөллийг нэмэгдүүлж, сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Архив бичиг хэргийн эрхлэгч /Ө.Ариунтунгалаг/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 01 сарын 20 ны өдрийн А/03 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**"СОЛОНГОС ХЭЛТЭЙ ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧДЫН
УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ" СУРГАЛТЫН
УДИРДАМЖ**

Сургалт явуулах үндэслэл:

Монгол улсад ирж буй жуулчдын 92 хувь нь Улаанбаатар хотоор дайран аялдаг ба үүний 10 хувийг Солонгос жуулчид эзэлдэг. Солонгос хэлний анхан болон дунд шатны мэдлэгтэй, солонгос жуулчдын сэтгэл зүйн болон үйлчилгээний онцлогийн талаар бүрэн дүүрэн ойлголтгүй хөтөч-тайлбарлагчид нийт хөтчүүдийн олонхийг бүрдүүлдэг. Энэ нь үйлчилгээний чанар, аяллын сэтгэл татах байдалд сөргөөр нөлөөлж буйг тур операторуудын зүгээс сануулж, эдгээр хөтчүүдийг давтан сургах, мэргэшүүлэх саналыг олноор тавьж байгаа юм. Энэ шаардлагын үүднээс солонгос хэлтэй хотын аяллын хөтчүүдэд зориулсан мэргэшүүлэх сургалтыг тус газраас санаачлан зохион байгуулж байна.

Зорилго:

Хөтөч-тайлбарлагч нь жуулчдын хамгийн ойрын харилцагч, туслагч, зөвлөгч, тухайн улсын үйлчилгээний салбарын нүүр царай болдог мэргэжилтнүүд юм. Жуулчид хөтөч-тайлбарлагчаас мэдээлэл аваад зогсохгүй тухайн улс үндэстний соёл, зан заншлын онцлогийг ч олж хардаг. Солонгос жуулчдад үйлчлэх хөтөч-тайлбарлагчдын ур чадварыг дээшлүүлэх, шаардлагатай мэдлэгийг эзэмшүүлэх, мэдээлэл өгөх, харилцааны соёлтой эелдэг боловсон үйлчилгээ үзүүлэх чадвартай хөтөч нарыг бэлтгэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Агуулга:

Солонгос жуулчдад хөтөч-тайлбарлагч хийхэд анхаарах зүйл, Монгол, Солонгосын соёлын ялгаа, аяллын хөтөч-тайлбарлагчийн мэдлэг чадварын тухай.

Сургалтын хөтөлбөр:

Сургалт нь өдөрт 3 цагаар 5 өдөр буюу 900 минут байна.

Хичээлийн хөтөлбөр

№	Хичээлийн ерөнхий агуулга	Дэлгэрэнгүй агуулга	Үргэлжлэх хугацаа	Огноо
1	Аялал жуулчлалын хөгжил ба Монгол	Аялал жуулчлалын хөгжлийн тухай	60 минут	2014.02.10
2	Солонгосын соёлын ялгаа	Монгол, Солонгос үндэстнүүдийн соёлын ялгаа	60 минут	
3		Хөтөч-тайлбарлагч мэргэжлийн онцлог, давуу талууд	60 минут	

4	Хөтчийн үүрэг	Хөтөч-тайлбарлагчийн үүрэг	60 минут	2014.02.11
5	хариуцлага ба	Зан заншлын ялгаа	60 минут	
6	газарчлах	Жуулчдын зорих газар – Музей, үзвэрийн газрууд	60 минут	
7	Жуулчдын зорих	Жуулчдын зорих газар-Сүм, хийд	60 минут	2014.02.12
8	газруудад тайлбар хийх	Жуулчдын зорих газар-Зайсан толгой ба түүний орчмын цэцэрлэгүүд	60 минут	
9		Жуулчдын зорих газар-УИД, Нарантуул зах, Чингисийн талбай гэх мэт	60 минут	
10	Жуулчдын зорих хот орчмын газруудад тайлбар	Жуулчдын зорих газар- Тэрэлж, Чингис хааны хөшөө, Манзушир, Хандгайт	60 минут	2014.02.13
11	хийх	Жуулчдын зорих газар- Хустай, Сонгины амралт г.м	60 минут	
12		Морин аялал, Тэмээн аялал, ууланд авирах, явган аялал, од ажиглах	60 минут	
13	Давтлага, шалгалт	Давтлага	60 минут	2014.02.14
14		Давтлага	60 минут	
15		Мэдлэг бататгах шалгалт	60 минут	

Хамрах хүрээ:

Солонгос хэлтэй, хөтөч-тайлбарлагчаар ажиллаж байсан туршлагатай Монгол улсын иргэд

Зохион байгуулагч:

Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Сургалт явагдах газар:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл, сурталчилгааны төвд

Хичээл заах багш:

Солонгос болон монгол багш нар

Сургалтын төлбөр:

Энэхүү сургалт нь үнэ төлбөргүй явагдана.


Хугацаа:

2014.02.10-14-ний өдрийн 18:00–21:00 цагт

Хүрэх үр дүн:

Солонгос жуулчдын зан төлөв, соёлын онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлж, жуулчдад оновчтой, сонирхолтой мэдээлэл өгч тайлбар хийснээр солонгос жуулчдын сэтгэл ханамж дээшилж, цаашид тус зах зээлээс ирэх жуулчдын тоо нэмэгдэнэ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
20¹⁴ оны 01 сарын 20-ний өдрийн А/03 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



"СОЛОНГОС ХЭЛТЭЙ ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧДЫН
УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ" СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төг/	Нийтүнэ /төг/
1	Багшийн ажлын хөлс	цаг	15	13,334	200.000
2	Гэрчилгээ хэвлүүлэх	ш	30	1.000	30.000
3	Бичиг хэргийн зардал	ш	30	1.000	30.000
4	Цайны зардал	ш	30	1334	40.000
Нийт дүн					300.000

Хянасан:
Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа

Төсөв зохиосон:
Архив, бичиг хэргийн эрхлэгч

Ө.Ариунтунгалаг